

**КАЗАХСТАН УЛСЫН ГАЗРЫН ХЭВЛИЙ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛЬ:
2010, 2017 ОНЫ ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

Г.Билгээ

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Нэг. Казахстан Улсын газрын хэвлий, түүнийг ашиглах хууль тогтоомжийн хөгжил

Хоёр. 2017 онд батлагдсан Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн ерөнхий танилцуулга

- Хуулийн төслийн зорилго
- Хуулийн зорилго, зорилт
- Хуулийн зарчим
- Газрын хэвлийг ашиглах тогтвортой байдлын баталгаа
- Хууль хүчин төгөлдөр болох
- Газрын хэвлийн өмчлөл
- Хуулиар зохицуулагдсан газрын хэвлийн нөөц
- Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны төрөл
- Геологийн мэдээлэл авах боломж

Гурав. 2010, 2017 оны Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулиудын харьцуулалт

- 2010, 2017 оны хуулиудын бүтцийн харьцуулалт
- Газрын хэвлийг ашиглах эрх
- Газрын хэвлийг ашиглагчийн эрх, үүрэг
- Газрын хэвлийг ашиглалтын салбар дахь төрийн байгууллагуудын тогтолцоо
- Газрын хэвлийг ашиглалтын салбар дахь төрийн удирдлага

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Бүгд Найрамдах Казахстан Улсын Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийн хөгжлийг хэд хэдэн үе шатанд хуваан үздэг. Тус улсад газрын хэвлийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан бие даасан хууль батлагдсанаас хойш эрх зүйн орчныг чангатгасан, үүний дараа гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн орчныг либералчласан, харин сүүлийн шинэчлэлээр газрын хэвлийг ашиглах эрх олгох тогтолцоог шинэчилсэн зэрэг өөрчлөлтүүдийг олон удаа хийж байна.

Хамгийн сүүлд Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр баталсан.²³⁰

Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид “газрын хэвлий” гэсэн нэр томъёог ОХУ²³¹ болон Армени²³², Беларусь²³³, Гүрж²³⁴, Казахстан²³⁵, Узбекистан²³⁶, Украин²³⁷ зэрэг хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан орнуудад түгээмэл хэрэглэдэг байна.

Казахстаны Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн 2.1-д энэ хуулийн үйлчлэх хүрээг заасан байна. Энэ хуулиар газрын хэвлийг ашиглах горим, газрын хэвлийг ашиглалтын салбар дахь төрийн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх журам, газрын хэвлийг ашиглах эрх үүсэх, хэрэгжүүлэх, дуусгавар болох, газрын хэвлийг ашиглагчийн эрх зүйн байдал болон явуулах үйл ажиллагаа, газрын хэвлий ашиглалт болон газрын хэвлийг ашиглах эрх болон бусад харилцааг зохицуулсан.

Шинэ хуулийн зохицуулалт нь дэлхийн шилдэг туршлагад нийцсэн, Казахстан Улсын газрын хэвлийг ашиглах салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн бөгөөд хөрөнгө оруулалтыг татахад томоохон ахиц дэвшил гаргах, шинэ ордыг нээх, нэмэлт ажлын байр бий болгох эрх зүйн үндэс болно хэмээн үзэж байна.

Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхийн тулд Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийг бүтцийн хувьд системчлэн, агуулгын хувьд дараах томоохон өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнд:

- тогтолцооны хувьд, төрийн байгууллагууд газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг чиглэл тус бүрээр хариуцаж ажиллах;
- тусгай зөвшөөрөл, гэрээний нөхцөлийн хэрэгжилтэд хяналт тавих журмыг тусгах;
- төрийн давуу эрх зөвхөн нүүрсустөрөгч, уран зэрэг стратегийн ач холбогдолтой салбаруудад хамаарах;
- газрын хэвлийг ашиглах нөхцөлийг тогтвортой байлгах баталгаа гаргах,
- газрын хэвлийг ашиглах эрх олгох журмыг тогтоохдоо үйл ажиллагааны онцлогоос нь хамааруулан тусгай зөвшөөрөл, гэрээний тогтолцоог хэрэглэх;
- геологи, газрын хэвлийг ашиглалтын талаарх мэдээлэл авах боломж;
- гар аргаар хатуу ашигт малтмал олборлох харилцааг зохицуулах;
- газрын хэвлийг ашиглагчийн нийгмийн хариуцлагын үүргийг тодорхой болгох;
- дотоодын зах зээлийг түүхий эдээр хангах;
- гэрээний дагуу газрын хэвлийн талбайг өөрчлөх зэрэг асуудлуудыг тусгасан.

Нэг. КАЗАХСТАН УЛСЫН ГАЗРЫН ХЭВЛИЙ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХӨГЖИЛ

Казахстаны хуульчдын үзэж байгаагаар тус улсын орчин үеийн газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийн хөгжлийг дор дурдсан үе шатуудад хуваан үзэж

²³⁰ Кодекс Республики Казахстан от 2017.12.27 № 125-VI “О недрах и недропользовании”. Эх сурвалж: https://online.zakon.kz/Document/?doc_id=31764592

²³¹ Закон Российской Федерации от 21.02.1992 № 2395-1 (ред. от 30.09.2017) “О недрах”.

²³² Кодекс Республики Армения от 2011.11.28 (ред. от 2017.12.21) “О недрах”.

²³³ Кодекс Республики Беларусь от 2008.07.14 № 406-3 (ред. от 2016.07.18) “О недрах”.

²³⁴ Кодекс Республики Грузии от 2017.05.23 “О недрах”.

²³⁵ Кодекс Республики Казахстан от 2017.12.27 № 125-VI “О недрах и недропользовании”.

²³⁶ Закон Республики Узбекистана от 1994.09.23 № 2018-XII (ред. от 2002.12.13) “О недрах”.

²³⁷ Кодекс Республики Украины от 2017.05.23 “О недрах”.

байна.²³⁸ Үүнд:

- I үе шат - 1990-1994 он;
- II үе шат - 1994-1999 он;
- III үе шат - 1999-2004 он;
- IV үе шат - 2004-2014 он;
- V үе шат - 2014 оноос хойш.

I үе шат (1990-1994 он) - Казахстан Улсад газрын хэвлийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан бие даасан хууль, эрх зүйн орчин бий болсон.

1992 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Газрын хэвлий, эрдэс түүхий эдийг боловсруулах тухай хуулиар уг харилцааг зохицуулах эрх зүйн үндэс тавигдсан. Удалгүй энэ хуулийн цоорхой, зөрчил олноор илэрсэн төдийгүй хуулийн үзэл баримтлал нь өөрөө эдийн засгийн цоо шинэ нөхцөл байдалд тохирохгүй байгаа нь тодорхой болсон.

Гэсэн ч энэ хугацаанд гадаадын хөрөнгө оруулагчид уул уурхай, газрын тосны төслүүдэд хөрөнгө оруулж эхэлсэн. Тухайлбал, Казахстаны хамгийн том төсөл болох Тенгизшевройл²³⁹ үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

II үе шат (1994-1999 он) - Казахстан Улсын хууль тогтоомжид газрын хэвлийг ашиглалтын үндсэн асуудлуудыг хамруулах гэж оролдсон.

Тухайн үед ихээхэн ач холбогдол бүхий Газрын тосны тухай (1995.06.28) болон Газрын хэвлийн тухай (1996.01.27) хуулиудыг баталсан. Гэвч эдгээр хуулиудаар гэрээ байгуулснаас хойш буюу уурхайн талбайг олборлолтод бэлтгэх, олборлох үе шатан дахь харилцааг зохицуулаагүй орхигдуулсан байв.

1996 оны Газрын хэвлийн тухай хуулийн онцлог нь газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл-гэрээний тогтолцоо; хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр ашигт малтмалын орд илрүүлсэн бол түүнийг олборлох тусгай зөвшөөрөл авах онцгой эрх; холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон бол тухайн өөрчлөлтөөс өмнө авсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх, үүргийг тогтворжуулах зэрэг асуудлууд юм.

Энэ үед Казахстанд газрын хэвлийг ашиглах журам харьцангуй чөлөөтэй (либерал) буюу хөрөнгө оруулагчдыг татахад чиглэж байсан бөгөөд холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор Казахстаны уул уурхай, газрын тосны салбарт хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татах боломжийг бүрдүүлсэн. Хөрөнгө оруулагчдын зүгээс Казахстаныг “хамгийн тааламжтай улс” болгохын тулд төр, засгийн зүгээс хүчин чармайлт гаргаж байгааг эерэгээр хүлээн авсан бөгөөд тус улсад газрын хэвлийг ашиглахын тулд актив болон газрын хэвлийг ашиглах эрх авч эхэлсэн. Тухайлбал, энэ хугацаанд "Южнефтегаз" ХК (одоогийн "ПетроКазахстан" ХК)-ийг Канадын "Hurricane Kumkol Limited" компани хувьчлан авсан. Хожим "Hurricane Kumkol Limited" компани нь "Южнефтегаз" үйлдвэрийн газартай хамтран "Казгермунай", "Тургай Петролеум"-ийн хувьцаа эзэмшигч болсон.

III үе шат (1999-2004 он) - Газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл-гэрээний тогтолцооноос дан гэрээний тогтолцоо руу шилжин гэрээний нөхцөлийг чангатгаж эхэлсэн.

1999 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Газрын хэвлийн тухай болон Газрын тосны тухай хуулиудад хэд хэдэн концепцийн шинжтэй өөрчлөлт орсон. Зарчмын томоохон шинэчлэл бол газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл-гэрээний тогтолцооноос дан гэрээний тогтолцоо руу шилжсэн явдал байв. Энэ нь газрын хэвлийг ашиглах гэрээний

²³⁸ "Законодательство о недрах и недропользовании: история вопроса и новая концепция". Ольга Ченцова, Наталья Брайнина. Журнал "Petroleum", 2015, №4, с. 60-67; №5, с. 74-81. Эх сурвалж: www.zakon.kz/4755276-zakonodatelstvo-o-nedrah-i.html

²³⁹ Тенгизшевройл нь Казахстан Улсын Засгийн газар, АНУ-ын "Шеврон" корпорацийн хооронд байгуулсан гэрээний дагуу 1993 онд байгуулагдсан бөгөөд газрын тос, хий, хүхэр зэрэг үндсэн түүхий эдийг боловсруулах тус улсын хамгийн том бөгөөд аюулгүйд тооцогддог компани. Эх сурвалж: www.tengizchevroil.com/ru/about/overview

үндсэн дээр эрх олж авах, цаашлаад хэвлий ашиглагч нь эрхээ хэрэгжүүлэх зэрэг үйл явцуудыг хялбаршуулсан.

Хуулийг хэрэгжүүлэх явцад Газрын хэвлий ашиглалтын салбар дахь зарим чухал асуудлууд мөн л зохицуулагдаагүй үлдсэн байв. Тухайлбал, хүрээлэн буй орчныг хамгаалах, далайн нөөцийг боловсруулах зэрэг зохицуулагдаагүй үлдсэн зарим асуудлууд байсан хэдий ч өмнөх хуулиар ямар нэгэн байдлаар зохицуулсан байжээ.

1999 оны өөрчлөлтөөр газрын хэвлий ашиглалтын эрх зүйн орчныг чангатгах зарим өөрчлөлтүүдийг оруулсан. Тухайлбал, тендер буюу сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн газрын хэвлийг ашиглах эрх олгох ерөнхий журмыг тогтоох; Үндэсний компаниуд, тэдгээрийн давуу эрхийг тодорхой заах; орон нутгийн үйлдвэрлэгчдээс бараа, ажил үйлчилгээ худалдан авахад илүү хатуу шаардлага тавих гэх мэт.

IV үе шат (2004-2014 он) - Газрын тос болон Газрын хэвлий ашиглалтын эрх зүйн орчныг чангатгахад чиглэсэн.

2004 оноос 2014 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд газрын тос, газрын хэвлийн хууль тогтоомж байнга өөрчлөгдөж байсан ба ингэхдээ эрх зүйн орчныг аль болох чангатгах бодлого барьж байжээ. Далай дотор газрын тос олборлох үйл ажиллагаанд бүтээгдэхүүн хуваах гэрээг ашиглах тухай хуулийг 2005 онд баталсан боловч 2009 онд хүчингүй болгосон. Түүнчлэн Газрын хэвлийн тухай болон Газрын тосны тухай хуулиудыг нэгтгэн Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль болгон өөрчилж, 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдөр баталсан.

2010 онд батлагдсан Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль (цаашид 2010 оны хууль гэх)-д өмнөх 1999 оны хуулийн гэрээний тогтолцоотой холбоотой харилцааг хэвээр үлдээсэн байна. Мөн 2010 оны хуулиар газрын хэвлий ашиглалтын компаниуд болон түүний туслан гүйцэтгэгчдийн аж ахуйн үйл ажиллагаанд төрөөс оролцох, хяналт тавих зэрэг асуудлуудыг хэвээр үлдээснийг Казахстаны энэ салбарын хөрөнгө оруулагчдад үзүүлэх дэмжлэг, хамгаалалт дутагдсан хэмээн зарим судлаачид шүүмжилдэг. Мөн экологи, татварын болон бусад хууль тогтоомжид ч хамааралтай зохицуулалтууд хэвээр байна.

Хууль тогтоогчид газрын хэвлий ашиглалтын хууль тогтоомжид олон удаа (5 жилийн хугацаанд 25 удаа) өөрчлөлт, шинэчлэл хийсэн байна.

V үе шат (2014 оноос хойш) - Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийг дахин либералчлах үйл явц эхэлсэн. Улс орны ашигт малтмалын нөөцийн санг нөхөх асуудал тулгарч, шинэ орд газруудыг хайж илрүүлэх, шинэ хөрөнгө оруулалт татах хэрэгцээ шаардлагыг харгалзан 2014 онд газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийн зарим зохицуулалтыг либералчилсан байна.

2014 оны 12 дугаар сарын 29-ний өдөр “Бүгд Найрамдах Казахстан Улс (цаашид “БНКУ”)–ын газрын хэвлий ашиглалтын асуудлаар зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль²⁴⁰ батлагдаж 2010 оны хуульд томоохон өөрчлөлт орсон. Энэ хуулийн нийт 129 зүйлийн 77-д нь өөрчлөлт орсон нь орчин үеийн газрын хэвлий ашиглалтын салбарын 15 жилийн түүхэнд хууль тогтоомжид оруулсан хамгийн том өөрчлөлтүүдийн нэг юм.

Үүний үр дүнд стратегийн ач холбогдол бүхий ордуудад төрийн давуу эрхийг зөвхөн гэрээгээр хязгаарлах; газрын хэвлийг ашиглах эрхийг тендерээр төдийгүй дуудлага худалдааны хэлбэр (шалгаруулалтын процедурыг хялбарчилсан, хугацааг богиносгосон хувилбар)-ээр олгох; 10 блок (нэгж тутам нь газарзүйн координатын тооцоогоор нэг минуттай тэнцүү)-оос хэтрэхгүй байх, бага судлагдсан газрын хэвлийд хайгуулын эрх авах журмыг хялбарчилаж ердийн хайгуулын гэрээ байгуулах зэрэг боломжуудыг бий болгосон.

Гэсэн хэдий ч газрын хэвлий ашиглалтын харилцааг зохицуулсан эрх зүйн хэм

²⁴⁰ Закон Республики Казахстана от 2014.12.29 № 271-V “О внесении изменений и дополнений в некоторые законодательные акты Республики Казахстан по вопросам недропользования”.

хэмжээг улам сайжруулах, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхийн тулд **Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн**²⁴¹ шинэчилсэн найруулгыг 2017 оны 12 дугаар сарын 27-ний өдөр баталсан.

Энэ хууль батлагдснаар БНКУ-ын орчин үеийн газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийн хөгжлийн V үе шат дуусаж дараагийн шатанд орж байна.

Хоёр. 2017 ОНД БАТЛАГДСАН ГАЗРЫН ХЭВЛИЙ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААРХ ТОЙМ ТАНИЛЦУУЛГА

Хуулийн төслийн зорилго²⁴²

Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай (цаашид “2017 оны хууль” гэх) хуулийн зорилго нь газрын хэвлий ашиглалтын салбарыг чанарын шинэ түвшинд гаргах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд газрын хэвлийг ашиглах, хамгаалах тухай хууль тогтоомжийн кодификацийг хийх замаар системчлэх явдал юм.

Түүнчлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх Казахстаны хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөгжүүлэх, хуулийн цоорхой, зөрчлийг арилгах, гадаадын орнуудад амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа эрх бүхий байгууллагуудтай төстэй шинэ байгууллагыг байгуулах, тус улсын ашигт малтмалын нөөцийн үр ашигтай ашиглалтыг хангах хууль эрх зүй, эдийн засаг болон нийгмийн нөхцөл, баталгааг тодорхойлоход уг хуулийн төслийг батлах зорилт оршино.

Хуулийн зорилго, зорилт (2017 оны хуулийн 3)

Улс орны эдийн засгийн өсөлт, нийгмийн сайн сайхны төлөө БНКУ-ын ашигт малтмал, түүхий эдийн суурь баазын тогтвортой хөгжлийг хангахад энэ хуулийн зорилго оршино. Хуулийн зорилтууд:

1. газрын хэвлийн төрийн өмчийн эрхийг хамгаалах;
2. газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн бодлогыг хэрэгжүүлэх, харилцааг зохицуулах;
3. БНКУ-ын төр, иргэдийн ашиг сонирхлыг болон газрын хэвлий ашиглагчдын эрхийг хангах;
4. БНКУ-ын ашигт малтмал, түүхий эдийн суурь баазыг хөгжүүлэх;
5. газрын хэвлийг ашиглах эрх үүсэх, хэрэгжүүлэх, өөрчлөх, дуусгавар болгох үндэслэл, нөхцөл, журмыг тогтоох;
6. газрын хэвлий ашиглалтыг тогтвортой хөгжүүлэх эрх зүйн үндсийг хангах;
7. газрын хэвлийн геологийн судалгаанд хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлэх;
8. газрын хэвлий ашиглалтын салбарын хуул тогтоомжийг бэхжүүлэх.

Хуулийн зарчим

2010, 2017 оны хуулиудад газрын хэвлий, түүнийг ашиглахтай холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалтын зарчмуудыг Хүснэгт 1-д харуулав.

²⁴¹ Кодекс Республики Казахстан от 2017.12.27 № 125-VI “О недрах и недропользовании”.

²⁴² Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: <http://mid.gov.kz/ru/>

Хүснэгт 1. 2010, 2017 оны хуулийн зарчмууд

2010 оны хуулийн 5-р зүйл	2017 оны хуулийн 4-р зүйл
<ol style="list-style-type: none">1. газрын хэвлийг зохистой, цогц, аюулгүй ашиглалтыг хангах;2. газрын хэвлий, байгаль орчныг хамгаалах;3. газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны ил тод байдал;4. газрын хэвлий ашиглалтын төлбөр;5. газрын хэвлий ашиглалтын нөхцөлийн тогтвортой байдал.	<ol style="list-style-type: none">1. газрын хэвлийн төрийн сангийн зохистой удирдлага;2. газрын хэвлийг ашиглахдаа экологийн аюулгүй байдлыг хангах;3. газрын хэвлийг ашиглах салбарын мэдээллийн хүртээмжтэй байдал;4. газрын хэвлийг ашиглах төлбөр;5. газрын хэвлий ашиглагчдын шударга байдал;6. газрын хэвлий ашиглалтын нөхцөлийн тогтвортой байдал

Газрын хэвлий ашиглалтын тогтвортой байдлын баталгаа (2017 оны хуулийн 31.7, 36.7)

Хэрэв БНКУ-ын хууль тогтоомжид газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл”)-ийн нөхцөлд өөрчлөлт орвол өөрчлөлт орохоос өмнө олгогдсон тусгай зөвшөөрөлд шинэ нөхцөлүүд хамаарахгүй.

Түүнчлэн БНКУ-ын хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтөөр газрын хэвлийг ашиглах гэрээгээр үйл ажиллагаа явуулах нөхцөлийг дордуулсан бол нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө байгуулсан гэрээнд шинэ нөхцөлийг хэрэглэхгүй.

Харин БНКУ-ын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, байгаль орчны аюулгүй байдал, эрүүл мэнд, татвар, гааль болон өрсөлдөөнийг зохицуулах хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт орсон бол дээрх баталгаанд хамаарахгүй.

Хууль хүчин төгөлдөр болох (2017 оны хуулийн 277.1)

Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийг албан ёсоор нийтлэгдсэн өдрөөс хойш **6 сарын дараа** хүчин төгөлдөр болно (зарим тодорхой заалтуудаас бусад).

Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийг “Казахстаны үнэн” сонины 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 249 (28628) дугаарт хэвлэгдсэн.

Газрын хэвлийн өмчлөл (2017 оны хуулийн 11)

Газрын хэвлий нь БНКУ-ын Үндсэн хуулийн²⁴³ дагуу төрийн өмчид байна.

Хуулиар зохицуулагдсан газрын хэвлийн нөөц

Энэ хуулиар газрын хэвлийн дараах нөөцийг ашиглах талаар зохицуулна. (2017 оны хуулийн 10.2) Үүнд:

1. ашигт малтмал;
2. техноген эрдэсийн хуримтлал;
3. газрын хэвлийн орон зай.

Ашигт малтмалыг эдийн засгийн шинжээр нь, мөн газрын хэвлийг ашиглах зохих нөхцөлийг тогтоох зорилгоор дараах байдлаар ангилна. (2017 оны хуулийн 12.2) Үүнд:

- а. газрын доорх ус;
- б. нүүрсустөрөгчийн ашигт малтмал (нүүрсустөрөгч);
- в. хатуу ашигт малтмал.

Техногенийн эрдэсийн хуримтлал нь ашигт малтмал, ашигт малтмалын агууламжтай уурхайн олборлолт, боловсруулалт болон эрчим хүчний үйлдвэрлэлээс гарсан хог хаягдлын хуримтлалыг ойлгоно. (2017 оны хуулийн 13.1)

²⁴³ БНКУ-ын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг. www.akorda.kz/ru/official_documents/constitution

Газрын хэвлийн орон зай нь газрын хэвлийн гурван хэмжээст орон зайн шинж чанартай бөгөөд геотехник, геологи, эдийн засаг болон экологийн хүчин зүйлсийг харгалзан үйлдвэрлэл, судалгаа шинжилгээ болон бусад үйл ажиллагааны объектыг байрлуулах талбай болгон ашиглана. (2017 оны хуулийн 16)

Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны төрөл (2017 оны хуулийн 22)

Газрын хэвлийг ашиглах эрхийг дараах үйл ажиллагаанд олгоно. Үүнд:

1. газрын хэвлийн геологийн судалгаа;
2. ашигт малтмалын хайгуул;
3. ашигт малтмалын олборлолт;
4. газрын хэвлийн орон зай ашиглалт;
5. гар аргаар ашигт малтмал олборлолт.

Геологийн мэдээлэл авах боломж

Газрын хэвлий ашиглалтын салбар дахь өөр нэг чухал шинэчлэл нь нууцын зэрэглэлтэй, эсхүл төрийн нууцтай холбоотойгоос бусад геологийн мэдээллийг нээлттэй байлгах аргаар тусгайлан заасан явдал юм. (2017 оны хуулийн 7.1, 64.1, 77) Геологийн мэдээлэл авах боломж нь 2017 хуулийн үндсэн зарчмуудын нэг юм. (2017 оны хуулийн 4)

Энэ салбарт тэргүүлж байгаа орнуудын туршлагаас үзэхэд, хөрөнгө оруулагчид геологийн чанартай мэдээллээр хангагдаж чадвал геологийн эрсдэл бага байдаг учраас тэд мэдээлэл сайтай газрын хэвлийг ашиглах сонирхол их байдаг байна. Олгогдсон газрын хэвлийг ашиглах эрх, түүний эзэмшигчид, тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн мэдээлэл нээлттэй байна. (2017 оны хуулийн 60, 65, 66, 77)

Гурав. 2010, 2017 ОНЫ ГАЗРЫН ХЭВЛИЙ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛИУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

2010, 2017 оны хуулиудын бүтцийн харьцуулалт

2010 оны Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль нь 15 бүлэг, 125 зүйлтэй (2017 оны 7 дугаар сарын 11-ний байдлаар).²⁴⁴

Харин 2017 оны Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль өөр бүтэцтэй: Ерөнхий болон Тусгай анги, 33 бүлэг, 268 зүйлтэй. Энэ хуулиар газрын хэвлийг ашиглахад ашигт малтмалын тодорхой төрөл тус бүрээр нь янз бүрийн харилцааг зохицуулсан; үйл ажиллагааны төрлөөс хамааран газрын тосны үйл ажиллагааг тусгаарлах, тухайлбал, нүүрсустөрөгчийн хайгуул болон олборлолтыг 2 тусдаа хэсэгт оруулсан байна. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. 2010, 2017 оны хуулиудын бүтцийн харьцуулалт

Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль (2010.06.24)	Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль (2017.12.27)
	ЕРӨНХИЙ АНГИ
	1-р хэсэг. Нийтлэг үндэслэл
	1-р бүлэг. Нийтлэг үндэслэл
1-р бүлэг. Нийтлэг үндэслэл	2-р бүлэг. Газрын хэвлий болон түүний нөөцийн талаарх нийтлэг үндэслэл
	2-р хэсэг. Газрын хэвлий ашиглалт
2-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн зохицуулалт	9-р бүлгээр зохицуулах болсон
3-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах эрх	
4-р бүлэг. Шалгаруулалтын үндсэн дээр газрын хэвлийг ашиглах эрх олгох	4-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах эрх олгох журам
5-р бүлэг. Шууд хэлэлцээрийн үндсэн дээр газрын хэвлийг ашиглах эрх олгох	

²⁴⁴ Закон Республики Казахстан от 2010.06.24 “О недрах и недропользовании” (с изменениями и дополнениями по состоянию на 2017.07.11). Эх сурвалж: <http://online.zakon.kz>

	§1. Газрын хэвлийг ашиглах зөвшөөрөл
6-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах гэрээ	§2. Газрын хэвлийг ашиглах гэрээ
	5-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах эрх болон эрхтэй холбоотой объектуудыг шилжүүлэх
	6-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагаа эрхлэх оператор
7-р бүлэг. Газрын хэвлий ашиглагчийн эрх, үүрэг	} 15-21-р бүлгүүдээр зохицуулах болсон
8-р бүлэг. Газрын тосны үйл ажиллагаа	
9-р бүлэг. Далай болон дотоодын усан санд газрын тосны үйл ажиллагаа явуулах	
9-1-р бүлэг. Техногенийн эрдэс боловсруулалт, ашиглалт	
10-р бүлэг. Хүчингүй болсонд тооцсон	
	3-р хэсэг. Газрын хэвлийн аюулгүй ашиглалт
11-р бүлэг. Газрын хэвлий, хүрээлэн буй орчны хамгаалалт, газрын хэвлий зохистой, нэгдсэн ашиглалт, хүн ам, ажиллах хүчний аюулгүй байдал	7-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтын аюулгүй ажиллагааны шаардлага
	8-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтаас гарсан үр дагаврыг арилгах
	4-р хэсэг. Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн удирдлага
2-р бүлгээр зохицуулж байсан	9-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн байгууллагуудын тогтолцоо
12-р бүлэг. Газрын хэвлийн хамгаалалт, судалгаа, ашиглалтад тавих төрийн хяналт	10-р бүлэг. Газрын хэвлий ашиглалтын салбар дахь хяналт тавих, мэдээлэх
13-р бүлэг. Газрын хэвлийн төрийн сан	11-р бүлэг. Газрын хэвлийн төрийн сан
	5-р хэсэг. Газрын хэвлий ашиглалттай холбоотой маргаан, газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, газрын хэвлийг ашиглах, хамгаалах чиглэлээрх олон улсын хамтын ажиллагаа
14-р бүлэг. Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	12-р бүлэг. Газрын хэвлий ашиглалттай холбоотой маргаан, газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага
	13-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах чиглэлээрх олон улсын хамтын ажиллагааны зорилго, зарчим, үндсэн чиглэл, төрөл
	ТУСГАЙ АНГИ
	6-р хэсэг. Геологийн судалгаа
	14-р бүлэг. Геологийн судалгаа хийх нөхцөл, журам
	7-р хэсэг. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт
	15-р бүлэг. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх олгох, дуусгавар болох
	§1. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрхийг дуудлага худалдаагаар олгох
2-р бүлгээр зохицуулж байсан	§2. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрхийг нүүрсустөрөгчийн салбар дахь үндэсний компанид шууд хэлэлцээрийн үндсэн дээр олгох
	§3. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх дуусгавар болох
	16-р бүлэг. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт хийх талбай, нутаг дэвсгэр
	17-р бүлэг. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт хийх хугацаа
	18-р бүлэг. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт хийх нөхцөл

2-р бүлгээр зохицуулж байсан	19-р бүлэг. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах төслийн баримт бичиг
	20-р бүлэг. Нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах
	21-р бүлэг. Нүүрсний давхаргын метаны хайгуул, олборлолтын онцлог, далай болон дотоодын усан сан, аюулгүй байдлын бүс дэх нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт
	8-р хэсэг. Уран олборлолт
2010 оны хуульд уран, хатуу ашигт малтмалын үйл ажиллагаатай холбоотой харилцааг ерөнхий байдлаар зохицуулсан.	22-р бүлэг. Уран олборлох чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх олгох болон дуусгавар болох
	§1. Уран олборлох чиглэлд газрын хэвлийг ашиглах эрхийг ураны салбар дахь үндэсний компанид шууд хэлэлцээрийн дагуу олгох
	§2. Уран олборлох чиглэлд газрын хэвлийг ашиглах эрх дуусгавар болох
	23-р бүлэг. Уран олборлох уурхайн газар нутаг, талбай
	24-р бүлэг. Уран олборлох хугацаа
	25-р бүлэг. Уран олборлох нөхцөл
	26-р бүлэг. Уран олборлох төслийн баримт бичиг
	9-р хэсэг. Хатуу ашигт малтмалын хайгуул, олборлолт
	27-р бүлэг. Хатуу ашигт малтмалын хайгуул
	28-р бүлэг. Хатуу ашигт малтмалын олборлолт
	29-р бүлэг. Хатуу ашигт малтмалын олборлолт явуулах талбайг хадгалах
	30-р бүлэг. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт
	31-р бүлэг. Хатуу ашигт малтмалыг хайх, олборлохын тулд газрын хэвлийн талбайг өөрчлөх
	32-р бүлэг. Хатуу ашигт малтмал боловсруулах тухай хэлэлцээр
	10-р хэсэг. Газрын хэвлийг ашиглах, гар аргаар ашигт малтмал олборлох, төгсгөлийн болон шилжилтийн нөхцөлүүд
	33-р бүлэг. Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагаа
	34-р бүлэг. Гар аргаар ашигт малтмал олборлох
15-р бүлэг. Төгсгөлийн болон шилжилтийн нөхцөлүүд	35-р бүлэг. Төгсгөлийн болон шилжилтийн нөхцөлүүд

ГАЗРЫН ХЭВЛИЙГ АШИГЛАХ ЭРХ

Газрын хэвлий ашиглагч (2017 оны хуулийн 18)

Газрын хэвлийг ашиглах эрх эзэмшигч (цаашид “газрын хэвлий ашиглагч”) нь хувь хүн, хуулийн этгээд байна. Газрын хэвлий ашиглагч нь нэгэн зэрэг хэд хэдэн хувь хүн, эсхүл хуулийн этгээд байж болно. Энэ тохиолдолд газрын хэвлийг ашиглах эрх нь дундынх байна. Газрын хэвлийг ашиглах дундын эрх нь газрын хэвлийг ашиглах эрхийг хоёр болон түүнээс дээш этгээдэд нэгэн зэрэг олгосон, эсхүл газрын хэвлийг ашиглах эрхийн зарим хэсгийг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэхэд үүснэ.

Газрын хэвлийг ашиглах эрх үүсэх үндэслэл (2017 оны хуулийн 20)

Газрын хэвлийг ашиглах эрх дор дурдсан үндэслэлээр үүснэ. Үүнд:

1. газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл;
2. газрын хэвлийг ашиглах гэрээ.

Газрын хэвлийг ашиглах эрхийг дараах тохиолдолд авна:

1. газрын хэвлийг ашиглах эрхийг эрх бүхий байгууллагаас олгох;
2. иргэний эрх зүйн хэлцлийн дагуу газрын хэвлийг ашиглах эрх (эсхүл эрхийн зарим

- хэсэг) шилжих;
3. хуулийн этгээд өөрчлөн байгуулагдах (өөрчлөн байгуулагдах замаар шинээр үүсгэх, эсхүл өв залгамжлах хамаарахгүй) замаар газрын хэвлийг ашиглах эрх шилжүүлэх.

Газрын хэвлийг ашиглах эрх олгох зохицуулалт

Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны төрлөөс хамаарч газрын хэвлийг ашиглах эрхийг тусгай зөвшөөрөл, эсхүл гэрээгээр олгохоор зохицуулсан байна.

Газрын хэвлийг ашиглах **тусгай зөвшөөрлийг** дараах үйл ажиллагаанд олгоно. (2017 оны хуулийн 30) Үүнд:

1. газрын хэвлийн геологийн судалгааны;
2. хатуу ашигт малтмалын хайгуулын;
3. хатуу ашигт малтмалын олборлолтын;
4. түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын;
5. газрын хэвлийн орон зай ашиглалтын;
6. гар аргаар хатуу ашигт малтмалын олборлолтын.

Харин дараах үйл ажиллагаанд газрын хэвлийг ашиглах эрхийг **гэрээгээр** олгоно. (2017 оны хуулийн 35.3) Үүнд:

1. нүүрсустөрөгчийн хайгуулын;
2. нүүрсустөрөгчийн олборлолтын;
3. ураны олборлолтын.

Газрын хэвлийг ашиглах эрх олгох журам

Шинэчилсэн найруулгад хатуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлсэн, харин нүүрсустөрөгч, ураны чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх үүсэх эрх зүйн хэрэгсэл болохын хувьд гэрээг хадгалж үлдсэн байна.

2010 оны хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах эрх олгох үйл явц 1,5-2 жил үргэлжилдэг байсан. Шинэ өөрчлөлтөөр тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг эрх бүхий байгууллага ажлын 10 хоногт хянаж үзэх, харин газрын хэвлийг ашиглах гэрээ байгуулах хугацаа 40 хоног хүртэл буурсан байна.

Хатуу ашигт малтмалын чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрхийг тухайн этгээдийн өргөдлийн дагуу тусгай зөвшөөрөл олгох замаар өрсөлдөөнгүйгээр олгоно:

1. газрын хэвлийн геологийн судалгааны - 3-аас доошгүй жил (2017 оны хуулийн 84.1);
2. хатуу ашигт малтмалын хайгуулын - дараалсан 6 жил (2017 оны хуулийн 193.1);
3. хатуу ашигт малтмалын олборлолтын - дараалсан 25-аас доошгүй жил (2017 оны хуулийн 211.1);
4. түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын - дараалсан 10-аас дээшгүй жил (2017 оны хуулийн 233.2);
5. газрын хэвлийн орон зай ашиглалт - дараалсан 25-оос дээшгүй жил (2017 оны хуулийн 256.1);
6. гар аргаар ашигт малтмал олборлолт - 3 жил. (2017 оны хуулийн 268)

Дуудлага худалдаанд үндэслэж байгаа газрын хэвлийг ашиглах эрхийг гэрээ байгуулах замаар олгоно:

1. нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт - дараалсан 6-аас дээшгүй жил, далайд нүүрсустөрөгчийн хайгуул, эсхүл хайгуулын хүнд төсөл - 9-өөс дээшгүй жил (2017 оны хуулийн 116.1);
2. нүүрсустөрөгчийн олборлолт - 25-аас дээшгүй жил, харин том бөгөөд өвөрмөц ордод нүүрсустөрөгчийн олборлолт - 45-аас дээшгүй жил (2017 оны хуулийн 120.1);
3. уран олборлолт - 25-аас дээшгүй жил (үүнд туршилтаар олборлолт хийсэн хугацааг оруулна). (2017 оны хуулийн 172.1)

2010 оны хуулиар зохицуулж байсан нүүрс устөрөгчийн үйл ажиллагааны 3 төрөл

(1.хайгуул, 2.олборлолт, 3.хайгуул, олборлолт хосолсон)-ийн гэрээний оронд 2017 оны хуулиар 2 төрлийн гэрээ (1.олборлолт, 2.хайгуул, олборлолт хосолсон) болсон байна.

2017 оны хуулиар хатуу ашигт малтмал (уранаас бусад)-ын чиглэлээр газрын хэвлийг ашиглах эрх олгох дараах журмыг тогтоосон. Үүнд:

1. **Өрсөлдөөний бус зарчмаар газрын хэвлийг ашиглах эрх олгох** зарчмыг дараах нөхцөлд хэрэглэнэ. Үүнд:
 - а) хатуу ашигт малтмал хайгуул, олборлолтын эрх (уранаас бусад);
 - б) газрын хэвлийн орон зайг ашиглах эрх;
 - в) гар аргаар ашигт малтмал олборлох тайлбай ашиглах эрх.
2. 2017 оны хуульд газрын хэвлийг ашиглах эрхийг **дуудлага худалдааны үндсэн дээр олгох** зохицуулалт хэвээр үлдээсэн. Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолтын чиглэлээрх газрын хэвлийг ашиглах эрхийг дуудлага худалдааны үндсэн дээр олгоно. (2017 оны хуулийн 93)

Газрын хэвлийг ашиглах эрх дуусгавар болгох (2017 оны хуулийн 21.2)

Газрын хэвлийг ашиглах эрх нь газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл, эсхүл гэрээ хүчингүй болсноор дуусгавар болно.

Тусгай зөвшөөрөл хүчингүй болох (2017 оны хуулийн 33)

1. олгосон хугацаа дууссан;
2. цорын ганц эзэмшигч нь нас барсан (тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үүссэн газрын хэвлийг ашиглах эрхийг БНКУ-ын иргэний хууль тогтоомжийн дагуу эзэнгүй өмч хэмээн үзнэ);
3. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, эсхүл хүчингүй болсонд тооцох;
4. газрын хэвлийг ашиглагч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон газрын хэвлийн талбайг ашиглахаас татгалзсан.

Гэрээ цуцлах (2017 оны хуулийн 38.1)

1. гэрээний дагуу хугацаа дууссан;
2. гэрээний дагуу газрын хэвлийг ашиглах цорын ганц эрх эзэмшигч нь нас барсан (гэрээний үндсэн дээр үүссэн газрын хэвлийг ашиглах эрхийг БНКУ-ын иргэний хууль тогтоомжийн дагуу эзэнгүй өмч хэмээн үзнэ);
3. газрын хэвлий ашиглагч хуулийн этгээд татан буугдсан;
4. гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах, эсхүл хүчингүй болсонд тооцсон;
5. гэрээг талууд тохиролцож цуцалсан;
6. Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн дагуу БНКУ-ын Засгийн газар газрын хэвлийн талбайг ашиглахыг хориглосон;
7. газрын хэвлийг ашиглах эрх эзэмшигч нь гэрээний дагуу газрын хэвлийн талбайг ашиглахаас татгалзсан (эсхүл буцаах).

Нүүрсустөрөгчийн чиглэлээрх гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болох үндэслэл (2017 оны хуулийн 106.1)

Хүчилтөрөгчийн чиглэлээрх гэрээг дор дурдсан шинэ үндэслэлээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно. Үүнд:

1. газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг хориглосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;
2. төслийн баримт бичгүүдийн шинжээчийн дүгнэлтгүйгээр нүүрсустөрөгчийн чиглэлээр газрын хэвлийг ашиглах үйл ажиллагаа явуулсан.

Газрын хэвлийн талбайг гэрээний дагуу өөрчлөх

Газрын хэвлийн талбайг гэрээний дагуу өөрчлөх асуудлыг 2010 оны хуульд талбайг зөвхөн таслах боломжтой байсан бол 2017 оны хуульд үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын төрлөөс хамааран талбайг нэмэх, багасгах, нийлүүлэх, таслах зэргээр өөрчилж болохоор зохицуулсныг Хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Газрын хэвлийн ашиглах талбайг өөрчлөх хувилбарууд

	Нэмэх	Багасгах	Нийлүүлэх	Таслах
Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт	✓	✓		✓
Ураны олборлолт	✓	✓		
Хатуу ашигт малтмалын хайгуул, олборлолт			✓	✓

Газрын хэвлийн геологийн судалгаа

2010 оны хуулийн 43.3-т газар доорх усны нөөцийн геологийн судалгааны ажлыг төсөв болон БНКУ-ын хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно гэж заасан нь хувийн хөрөнгө оруулагчдад энэ төрлийн үйл ажиллагаа явуулах боломжийг олгосон.

Гэтэл энэ хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээгээр хөрөнгө оруулалт нь үр ашиггүй байна гэж дүгнэжээ. Тухайлбал, геологийн судалгааны үр дүнгээр хувийн хөрөнгө оруулагчдад эдийн засгийн эерэг үр нөлөө байдаггүй, тэд гаргаж авсан геологийн мэдээллээ худалдах, эсхүл өөрөөр ашиглах боломжгүйгээр төрд шилжүүлдэг байна.²⁴⁵

Тийм учраас 2017 оны хуулиар геологийн бүх эрсдэлийг төр хариуцах төрийн хөрөнгөөр газрын хэвлийн геологийн судалгааг гэрээгээр гүйцэтгэхийн зэрэгцээ энэ салбарт хувийн хөрөнгө оруулагчдыг татах механизмыг тодорхойлж өгсөн.

Геологийн судалгаа гүйцэтгэгч нь өөрийн хөрөнгөөр, эрсдэлээ өөрөө хариуцан газрын хэвлийн геологийн судалгаа хийсэн бол судалгаанаас гарсан геологийн мэдээллийг төрд өгөх үүрэгтэй. Төр нь тухайн мэдээллийг тогтоосон хугацаанд хадгалах үүрэгтэй бөгөөд хадгалах хугацаа дуусахад мэдээллийг нийтэд нээлттэй болгоно. Энэхүү тогтоосон хугацаанд геологийн судалгаа гүйцэтгэгч нь геологийн мэдээллээ хуулиар тогтоосон журмын дагуу сонирхогч талуудад зарах эрхтэй бөгөөд энэ харилцааг хуулиар зохицуулсан байна. **(2017 оны хуулийн 90-92)**

ГАЗРЫН ХЭВЛИЙ АШИГЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Хадгалалтын статус (2017 оны хуулийн 222)

2017 оны хуульд хатуу ашигт малтмалын хувьд хадгалах статусыг шинээр тусгасан байна. Хадгалалтын статус бол тусгай зөвшөөрөлд заасан талбайд хатуу ашигт малтмалын олборлолтыг дараалсан 5 жил хүртэлх хугацаанд эхлүүлэхгүй байх, эсхүл түр зогсоох, эрхийн хувьд дахин дараалсан 5 хүртэлх жил сунгах эрхийг олгоно.

Төслийн баримт бичиг (2017 оны хуулийн 23)

2017 оны хуульд ашигт малтмалын төрлөөс хамааран төслийн баримт бичгийн бүтэц болон төрөлд өөрчлөлт оруулсан.

2010 оны хуулиар төслийн баримт бичигт техник-эдийн засгийн үзүүлэлтүүдийг тусгах бөгөөд дараа нь ажлын хөтөлбөрт үүнийг оруулахдаа жил бүрийн зардлыг тэмдэглэх үүрэгтэй байсан. Шинэчлэгдсэн хуульд энэхүү журмыг шинэчилсэн. Одоо төслийн баримт бичгүүдийн техник-эдийн засгийн үзүүлэлтүүдийг илүү анхаарах бөгөөд энэ нь үүргийн хангалтад хяналт тавих шалгуур үзүүлэлт болно.

Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны үр дагаврыг арилгах үүрэг

2010 оны хуулиар газрын хэвлийн ашиглагч нь үр дагаврыг арилгах үүргээ биелүүлэхийн тулд БНКУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аль ч банканд тусгай хадгаламжийн дансанд мөнгөн хөрөнгө байршуулах замаар үр дагавар арилгах санг байгуулах ёстой. Үр дагавар арилгах сан байгуулах журам, тус сангаас хасагдах мөнгөн дүн, төлбөрийн давтамжийг газрын хэвлий ашиглагчтай байгуулсан гэрээгээр

²⁴⁵ Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: <http://mid.gov.kz/ru/>

тогтоож байсан.

Шинэчилсэн найруулгад газрын хэвлий ашиглагчийн үйл ажиллагааны үр дагавар арилгах үүргийн нөхцөлд өөрчлөлт орсон.

Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны үр дагаврыг арилгах нь Казахстаны хууль тогтоомжид заасны дагуу үйлдвэрлэлийн объект, газар нутгийг хүн амын амь нас, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалсан, аюулгүй байдлыг хангасан нөхцөлд хүргэхийн тулд явуулах үйл ажиллагааны цогц юм. (2017 оны хуулийн 54, 55)

Үр дагаврыг арилгах ажиллагаа нь газрын хэвлийг ашиглах эрх дууссан талбай дээр хийх бөгөөд ингэхдээ санхүүгийн хэрэгслийг ашиглах замаар дараах механизмыг ашигласан байна. Үүнд:

1. батлан даагч;
2. банкны хадгаламжийн барьцаа;
3. даатгал.

Үр дагаврыг арилгах үүргээ биелүүлээгүй, эсхүл тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд тогтоосон хэмжээгээр төрөөс авах аюулгүй байдлын хэмжээг авна.

1. Үр дагаврыг арилгах үүргийг хангах батлан даагч - газрын хэвлийн ашиглалтын үйл ажиллагааны үр дагаврыг бүрэн, эсхүл хэсэгчлэн арилгахын тулд газрын хэвлий ашиглагчийн хүлээсэн үүргийг хангахын тулд төрийн өмнө батлан даах үүрэгтэй. (2017 оны хуулийн 56)

2. Банкны хадгаламжийн барьцаа - үр дагаврыг арилгах үүргээ биелүүлээгүй тохиолдолд төр банкны хадгаламжийн барьцаанаас тодорхой мөнгөн дүнг тенге, эсхүл гадаад валютаар авч болно. (2017 оны хуулийн 57)

3. Даатгал - газрын хэвлий ашиглагч нь үр дагаврыг арилгах үүргээ баталгаажуулахын тулд даатгалын байгууллагатай даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд хэрэв тэрээр энэхүү үүргээ хангаагүй бол даатгалын байгууллага зохих төлбөрийг төрд төлнө. (2017 оны хуулийн 58)

Дотоодын зах зээлийг түүхий эдээр хангах

Өмнөх хуульд байсан газрын хэвлий ашиглагчийн дотоодын зах зээлийг түүхий эдээр ханган нийлүүлэх үүргийг гэрээний дагуу зохицуулж байсан. Харин энэ үүргийг 2017 оны хуульд тусгайлсан зохицуулалт тусгасан бөгөөд газрын хэвлий ашиглагч нь БНКУ-ын нутаг дэвсгэрт боловсруулах газрын тосны хэрэгцээг хангахын тулд хуваарийн дагуу нийлүүлэх үүрэг хүлээсэн. (2017 оны хуулийн 118.2, 123.14, 130.1)

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам (2017 оны хуулийн 131, 213)

Нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт болон хатуу ашигт малтмалын олборлолт (үүнд гэрээт гүйцэтгэгчид хамаарна)-ын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ авахдаа дараах аргуудын аль нэгээр гүйцэтгэнэ.

1. нээлттэй сонгон шалгаруулалт;
2. нэг эх сурвалжаас;
3. цахим нээлттэй сонгон шалгаруулалт;
4. бараа таваарын бирж дээрээс.

Нүүрс устөрөгчийн хайгуул, олборлолт, хатуу ашигт малтмалын олборлолт (гэрээт гүйцэтгэгчид)-ын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ авах журмыг **нүүрс** устөрөгчийн болон хатуу ашигт малтмалын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагууд батална.

Газрын хэвлий ашиглагчийн нийгмийн хариуцлагын үүрэг

Газрын хэвлий ашиглагч нь нийгмийн хариуцлагын хүрээнд дор дурдсан ажлуудыг санхүүжүүлэх талаар тодорхой заасан. (2017 оны хуулийн 178) Үүнд:

- Казахстаны боловсон хүчний сургалт - олборлолтын зарлагын 1%;

- судалгаа, шинжилгээний ажил - олборлолтын зарлагын 1%;
- бүс нутгийн нийгэм, эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжил - гэрээний дагуу хөрөнгө оруулалтын 1%-ийг тус тус бүрдүүлнэ.

Дээрх үүргүүд нь зөвхөн олборлолтын хугацаанд үүсэх бөгөөд үйл ажиллагааныхаа хоёр дахь жилээс эхлэн хэрэгжүүлнэ.

2017 оны хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд, өмнөх зохицуулалтаар энэ үүрэг нь газрын хэвлий ашиглагчдад хайгуулын үйл ажиллагааны өндөр өртөгтэй зэрэгцэн нэмэлт санхүүгийн дарамт болж байсан учраас хөрөнгө оруулагчид эрсдэлд оруулж байжээ.

Ашигт малтмал олборлох шинэ арга (2017 оны хуулийн 263-276)

2017 оны хууль нь гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичиг уурхайг шинээр оруулсан. Гар аргаар хатуу ашигт малтмал олборлох энэхүү шинэ арга нь химийн урвалаас бусад зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл, төхөөрөмжөөр тогтоосон нутаг дэвсгэрт ашигт малтмал гаргаж авах арга юм.

Гар аргаар хатуу ашигт малтмал олборлох дор дурдсан ерөнхий нөхцөлийг шинэчилсэн найруулгад тусгасан байна. Үүнд:

1. үнэт металл, үнэт чулуу олборлох;
2. гар аргаар хатуу ашигт малтмал олборлох субъект - БНКУ-ын иргэн байх;
3. олборлох эрх үүсэх үндэслэл - тусгай зөвшөөрөл олгох (тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтийн дагуу);
4. тусгай зөвшөөрлийн хугацаа – 3 жил (тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтээр нэг удаа 3 жилээр сунгана);
5. тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, эсхүл солилцохыг хориглосон;
6. тусгай зөвшөөрлийг орон нутгийн захиргааны байгууллага, улсын чанартай хот олгоно;
7. олборлолт явуулах гүнийн хэмжээнд хязгаарлалт тогтоосон;
8. гар аргаар хатуу ашигт малтмал олборлох үйл ажиллагааны үр дагаврыг арилгах үүрэгтэй.

Казахстаны нутаг дэвсгэр дээр алтны олборлолтыг ихэвчлэн гар аргаар гүйцэтгэж байгаа. Иймд олборлолтын энэ аргыг хууль тогтоомжоор зохицуулснаар хууль бус олборлолтыг зогсоох, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, улсын төсөвт нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх боломж бүрдэж байгааг 2017 оны хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан байна.²⁴⁶

ГАЗРЫН ХЭВЛИЙ АШИГЛАЛТЫН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО

Төрийн удирдлагын шинэ арга зүй

Газрын хэвлий, түүнийг ашиглах тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд²⁴⁷, 2017 оны хуулиар газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн удирдлагын шинэ арга, хандлагыг нэгтгэсэн байна.

Захиргааны хүнд суртлыг багасгах, хатуу ашигт малтмалын (уранаас бусад) чиглэлээрх газрын хэвлий ашиглалтад төрийн хяналт тавих үйл явцыг хялбарчлах үүднээс газрын хэвлий ашиглагчид үйл ажиллагааны тодорхой үр дүнд хүрэхийг шаардах болсон байна.

Энэ арга нь газрын хэвлий ашиглагч нарт зохих шалгуурт хүрэхийн тулд экологийн болон үйлдвэрлэлийн аюулгүй байдлын шаардлагад нийцсэн газрын хэвлий ашиглалтын үйл ажиллагааг хэрхэн явуулах, хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт ямар техник, технологи, аргыг нэвтрүүлэх, ашиглахаа бие даан шийдвэрлэх боломж гарч байгаа аж.

²⁴⁶ Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: <http://mid.gov.kz/ru/>

²⁴⁷ Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: <http://mid.gov.kz/ru/>

Энэхүү аргыг нэвтрүүлснээр газрын хэвлий ашиглалтын салбарынхнаас улсаас тогтоосон олон тооны зохицуулалтыг "багасгаж", шинэлэг, үр ашигтай, аюулгүй, өмнө нь Казахстанд ашиглаж байгаагүй технологийг оруулахад дэмжлэг үзүүлнэ хэмээн үзэж байна.

Төрийн байгууллагуудын тогтолцооны харьцуулалт

2010 оны хуулийн "Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн зохицуулалт" гэсэн 2 дугаар бүлэгт дор дурдсан төрийн байгууллагуудыг тусгасан байна. Үүнд:

1. БНКУ-ын Засгийн газар;
2. газрын хэвлийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
3. нефт, байгалийн хийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
4. үйлдвэрлэл, инновацийн үйл ажиллагаан дахь төрийн дэмжлэг хариуцсан эрх бүхий байгууллага;
5. газрын хэвлийн судалгаа, ашиглалт хариуцсан эрх бүхий байгууллага;
6. ашигт малтмалын хайгуул, боловсруулалтын төв хороо;
7. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, боловсруулалтын бүс нутаг дундын хороо;
8. газрын хэвлийг ашиглах эрх олгох шалгаруулалтын хороо;
9. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын эрх олгох шалгаруулалтын хороо;
10. төрийн давуу эрхийг хэрэгжүүлэх асуудал хариуцсан салбар дундын хороо;
11. газрын хэвлийг ашиглах асуудал хариуцсан шинжээчдийн хороо;
12. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын асуудал хариуцсан шинжээчдийн хороо;
13. байгаль орчин хамгаалах асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
14. муж, улсын чанартай хот, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд.

2017 оны хуулийн "Газрын хэвлий ашиглалтын салбар дахь төрийн байгууллагуудын тогтолцоо" гэсэн 9 дүгээр бүлэгт дор дурдсан төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тусгасан байна. Үүнд:

1. БНКУ-ын Засгийн газар;
2. асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
3. хатуу ашигт малтмалын асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
4. нүүрсустөрөгчийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
5. ураны олборлолтын асуудал хариуцсан эрх бүхий байгууллага;
6. газрын хэвлийн судалгаа хариуцсан эрх бүхий байгууллага;
7. муж, улсын чанартай хот, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд.

Эндээс харахад, газрын хэвлий ашиглалтын салбарт төрийн удирдлага хангах байгууллагууд нь газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааны чиглэлд тус бүрээр асуудлаа хариуцан ажиллахаар болсон байна. Тухайлбал, 2017 оны хуулиар төрийн давуу эрхийг хэрэгжүүлэх асуудал хариуцсан салбар дундын хорооны чиг үүргийг тухайн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага хэрэгжүүлэхээр болсон байна.

ГАЗРЫН ХЭВЛИЙ АШИГЛАЛТЫН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН УДИРДЛАГА

БНКУ-ын Засгийн газрын бүрэн эрх (2017 оны хуулийн 59)

1. Төрийн өмчийн объект болох газрын хэвлийг удирдах ажлыг зохион байгуулах, газрын хэвлийн салбар дахь төрийн бодлогын үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэх стратеги, тактикийн арга хэмжээг боловсруулах;
2. үндэсний аюулгүй байдлыг хангах, хүн амын амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор газрын хэвлий ашиглалтад тавигдах хязгаарлалт, хоригийг тогтоох;
3. стратегийн ач холбогдол бүхий газрын хэвлийн талбайн жагсаалтыг батлах.

Хатуу ашигт малтмалын асуудал **хариуцсан** эрх бүхий байгууллагын бүрэн эрх

(2017 оны хуулийн 61)

1. Энэ хуульд заасан хатуу ашигт малтмалын (уранаас бусад) хайгуул, олборлолтын салбарын эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
2. хатуу ашигт малтмалын (уранаас бусад) олборлолтын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
3. татан буулгах төлөвлөгөөнд цогц шинжилгээ хийх;
4. чулуулгийн массыг гаргаж авах, (эсхүл) хайгуулын талбай руу 1000 куб метрээс дээш хэмжээтэй хөрс шилжүүлэх зөвшөөрөл олгох;
5. хатуу ашигт малтмалын хайгуул, олборлолтын (ураны олборлолтоос бусад) үйл ажиллагааг зохицуулах;
6. хатуу ашигт малтмалын хайгуул, олборлолтын (уран болон түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтоос бусад) үйл ажиллагаанд хяналт тавих.

Нүүрсустөрөгчийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагын бүрэн эрх (2017 оны хуулийн 62)

1. Энэ хуульд заасан нүүрсустөрөгчийн салбарын эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
2. нүүрсустөрөгчийн салбарын норм-техникийн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
3. нүүрсустөрөгчийн чиглэлээрх газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих;
4. төслийн баримт бичгийн журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
5. газрын тос, шатдаг хийн олборлолт, эргэлтийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх;
6. газрын тосны бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн хэрэгцээг хангахын тулд Казахстаны нутаг дэвсгэрт болон түүний гадна боловсруулах газрын тос нийлүүлэх хуваарийг бүрдүүлэх;
7. далай болон дотоодын усан санд нүүрсустөрөгчийн хайгуул, олборлолт явуулахад ашиглах далайн объектуудыг барих, байршуулах зөвшөөрөл олгох;
8. бамбарт шатдаг хий шатаах зөвшөөрөл олгох;
9. нүүрсустөрөгчийн үйлдвэрлэл, борлуулалт болон хэрэглээний үндэсний тэнцвэрт байдлыг хангах;
10. нүүрсустөрөгчийн хайгуул, (эсхүл) олборлолтын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
11. БНКУ-ын далай, дотоодын усан сан болон аюулгүй байдлын бүсэд газрын тосны алдагдлыг устгах бэлэн байдал болон хариу арга хэмжээний үндэсний төлөвлөгөөг иргэний хамгаалалт, далайн худалдааны асуудал хариуцсан эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж батлах.

Ураны олборлолтын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагын бүрэн эрх (2017 оны хуулийн 63)

1. Энэ хуульд заасан уран олборлолтын салбарын эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
2. уран олборлолтын салбарын норм-техникийн баримт бичгүүдийг боловсруулж батлах;
3. уран олборлолтын чиглэлээрх газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих;
4. төслийн баримт бичгийн журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
5. уран олборлох явцад газрын хэвлийг зүй зохистой, цогцоор нь ашиглаж байгаа эсэхэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
6. уран олборлолтын үйл ажиллагаа явуулахад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын хэрэгжилтэд төрийн хяналтыг хэрэгжүүлэх.

Улс, мужийн чанартай хот, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүрэн эрх (2017 оны хуулийн 65)

1. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох эрх олгох;
2. газрын хэвлий ашиглагч түгээмэл тархацтай ашигт малтмал, гар аргаар ашигт малтмал олборлолтын тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж байгаа эсэхэд болон эдгээрийн олборлолтын үйл ажиллагаанд төрийн хяналт тавих;
3. БНКУ-ын газрын тухай хууль тогтоомжийн дагуу газрын хэвлийг ашиглах зориулалтаар төрийн өмчийн газар өмчлөх, эзэмших эрх олгох;
4. ашигт малтмал тархац бүхий нутаг дэвсгэрийн барилга байгууламжийг зохицуулах, орон нутгийн ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалттай газар нутгийн болон орон нутгийн ач холбогдол бүхий онцгой хамгаалалттай байгалийн газар нутагт хамаарах экологи, судалгаа шинжилгээ, түүх, соёл, амралтын онцгой үнэ цэнэтэй газрын хэвлийн нутаг дэвсгэрийн объектын геологи, геоморфологи, гидрогеологийн санг хөтлөх;
5. суурин газрын усан хангамжийг бүрдүүлэхийн тулд газар доорх усны нөөц илрүүлэх чиглэлээр улсын геологийн судалгааг зохион байгуулах, явуулах;
6. өөрсдийн олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлох, гар аргаар ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл олгох;

Газрын хэвлий ашиглалтад тавих хяналт (2017 оны хуулийн 47.5)

2017 оны хуульд хяналтын шууд ба шууд бус хэлбэрийг тогтоож, түүнийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудыг тодорхой заасан байна.

Шууд хяналтыг дараах аргуудын аль нэгээр нь хэрэгжүүлнэ. Үүнд:

- хуулийн этгээд, эсхүл бусад байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрхийн 25-аас дээш хувийг эзэмших;
- байгууллагын удирдах дээд байгууллагад нийт саналын 25-аас дээш хувийн саналын эрхтэй;
- газрын хэвлий ашиглагчийн хуваарилах цэвэр орлогын 25-аас дээш хувийг авах;
- гэрээ, эсхүл Казахстаны хууль тогтоомжид заасны дагуу бусад байгууллагаас гаргасан шийдвэрийг тодорхойлох эрхтэй.

Шууд бус хяналт нь тухайн байгууллагыг шууд хянадаг гуравдагч байгууллагаар дамжуулан өөр хуулийн этгээд хянахыг ойлгоно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Конституция РК. Эх сурвалж: www.akorda.kz/ru/official_documents/constitution
- Кодекс Республики Казахстан от 2017.12.27 № 125-VI “О недрах и недропользовании”. Эх сурвалж: <https://online.zakon.kz>
- Сенат принял проект Кодекса о недрах и недропользовании. Эх сурвалж: www.zakon.kz
- “Законодательство о недрах и недропользовании: история вопроса и новая концепция». Ольга Ченцова, Наталья Брайнина. Журнал “Petroleum”, 2015, №4, с. 60-67; №5, с. 74-81. Эх сурвалж: www.zakon.kz
- Закон Республики Казахстана от 2014.12.29 № 271-V “О внесении изменений и дополнений в некоторые законодательные акты Республики Казахстан по вопросам недропользования”.
- Концепция проекта Кодекса Республики Казахстан «О недрах и недропользовании». Эх сурвалж: <http://mid.gov.kz/ru/>